



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосон-Илч ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/15/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: М.Мөнхтөгс
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/260
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ТОСОН-ИЛЧ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БЯМБАЦОГТ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тосон-Илч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Тосон-Илч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд 1200 кв-ын хүчин чадалтай 2 тогоог сайжруулан, 150 сая төгрөгийн 2200 кв-ын усан халаалтын тогоог худалдан авч, байгууллагын халаалтын хүчин чадлыг нэмэгдүүлэн шинэчлэлт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар тайлагнал, бүртгэлтэй холбоотой 22.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Бусад асуудлын хэсэг

“Тосон-Илч” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 09 дугаар тогтоолоор нийт орлогыг 563,3 сая төгрөгөөр, нийт зардлыг 686.8 сая төгрөгөөр байхаар нэмэлт тодотгол хийж 101 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040640

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	178,582,969.68	1,388,855.99
1.1.2	Дансны авлага	8,707,987.00	14,298,933.00
1.1.6	Бараа материал	59,221,501.09	65,501,325.69
1.2.1	Үндсэн хөрөнгө	205,708,910.53	374,847,329.24
1.2.2	Биет бус хөрөнгө	13,572,000.00	13,572,000.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	474,483,382.84	494,603,089.03
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,192,434.58	71,064,309.30
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	473,290,948.26	423,538,779.73
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	474,483,382.84	494,603,089.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	561,721,975.82	567,184,788.18
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	464,998,898.29	546,507,634.79
3	Нийт ашиг (алдагдал)	96,723,077.53	20,677,153.40
8	Бусад орлого	56,371,510.00	65,987,956.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	97,854,055.29	136,417,277.93
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	55,240,532.24	(49,752,168.53)
19	Орлогын татварын зардал	5,524,053.22	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	49,716,479.02	(49,752,168.53)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	0.00	(49,752,168.53)
24	Орлогын нийт дүн	49,716,479.02	(49,752,168.53)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	209,249,812.17	473,290,948.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	209,249,812.17	473,290,948.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(49,752,168.53)	(49,752,168.53)
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	159,497,643.64	423,538,779.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	645,095,395.59	619,293,128.51
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	645,074,395.59	618,640,370.51
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	106,958.00
	Бусад мөнгөн орлого	21,000.00	545,800.00
1.2	Мөнгөн зарлага (-)	588,541,039.32	614,934,242.20
	Ажиллагчдад төлсөн	208,261,454.66	249,676,007.32
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	28,257,151.52	35,443,115.22
	Бараа материал худалдан авахад төлсөн	183,229,866.50	112,898,847.50
	Ашиглалтын зардалд төлсөн	43,002,757.12	68,840,888.91
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	62,066,134.20	88,293,218.00
	Татварын байгууллагад төлсөн	39,906,537.36	33,728,076.74
	Даатгалын төлбөрт төлсөн	54,450.00	-
	Бусад мөнгөн зарлага	23,762,687.36	26,054,088.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	56,554,356.27	4,358,886.31
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	35,713,636.36	181,553,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	35,713,636.36	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	181,553,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(35,713,636.36)	(181,553,000.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	-
	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,000,000.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	10,840,719.91	(177,194,113.69)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	167,742,249.77	178,582,969.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	178,582,969.68	1,388,855.99

2.5 ТУЗ-аар батлагдсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2023 оны төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
		IV=I+II+III	V	VI=V-IV	VII=V/IV
1	Халаалтын орлого	539,592,360	538,867,568.2	(724,792)	100%
2	Цэвэр усны орлого	11,000,000	11,114,910.9	114,911	101%
4	Халуун усны орлого	11,032,337	14,983,218.2	3,950,881	136%
5	Хогны төлбөрийн орлого	1,356,000	1,818,181.8	462,182	134%
6	Түрээсийн орлого	360,000	400,909.1	40,909	111%
Орлогын дүн		563,340,697	567,184,788	3,844,091	101%
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	242,507,457	242,507,457	-	100%
2	НДШимтгэлийн зардал	35,848,757	35,848,757	-	100%
3	Нүүрс	75,970,000	75,970,000	-	100%
4	Шатахуун	12,276,000	12,276,000	-	100%
5	Тээврийн зардал	95,645,748	95,645,748	-	100%
6	Гэрэл цахилгаан	61,331,749	61,331,749	-	100%
7	Бичиг хэрэг	965,000	965,000	-	100%
8	Цахилгаан холбоо	945,000	945,000	-	100%
9	Албан томилолт	1,620,000	1,620,000	-	100%
10	Хангамжийн материал	14,893,236	14,893,236	-	100%
11	Хөдөлмөр хамгаалал	17,907,500	15,969,500.0	(1,938,000)	89%
12	Урсгал засвар	12,153,622	12,153,621.8	-	100%
13	Төлбөр хураамж	6,112,687	12,225,374.3	6,112,687	200%
14	Авто сэлбэг	5,641,000	400,000.0	(5,241,000)	7%
15	Түлээ	3,500,000	720,000.0	(2,780,000)	21%
16	Нохой устгал	2,325,000	2,325,000.0	-	100%
17	ТУЗ зардал	6,887,000	6,887,000.4	-	100%
18	Тэтгэмж дотоод журмаар	17,760,000	17,760,000.0	-	100%
19	Үндсэн хөрөнгийн элэгдэл	72,480,670	72,481,468.5	799	100%
20	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	686,770,426	682,924,912	(3,845,514)	99%
21	Үйл ажиллагааны бус орлого, зардал	-	65,987,956	-	-
22	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(123,429,729)	(49,752,168)	7,689,605	40%

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, тайлагналтай холбоотой 58.6 сая төгрөгийн алдаа залруулж, 9.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, худалдан авалттай холбоотой 12.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 22.0 сая төгрөг байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангаарх борлуулалтын орлогоос 58.6 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Тээврийн шугам ХХК-тай нүүрс, ачаа тээвэрлэлтийн гэрээнд 9.7 сая төгрөгийн үнийн зөрүү тооцож, ТУЗ-ын тушаалаар олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20.5, 41.2 гэсэн заалтуудтай батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдэлттэй холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй 12.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Борлуулалтын орлого НӨАТ-н тайлан, санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнагдсан	1	58.6			1	58.6	1	58.6		
Дүн	1	58.6			1	58.6	1	58.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримт бүрдэлттэй холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	12.3					1	12.3
Тэнгэрийн шугам ХХК-тай нүүрс, ачаа тээвэрлэлтийн гэрээнд үнийн зөрүү тооцож, ТУЗ-ын тушаалаар олгосон.	1	9.7			1	9.7		
Дүн	2	22.0			1	9.7	1	12.3

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1				1			



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 03 сарын 15 өдөр

№ 58/АЭЭТ0439/ХӨА-2024/
15/АА-СМД-ОАА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Тосон Илч ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нүүрс тээвэрлэх гэрээний үнийг нэмэгдүүлэн 9,783,356.0 /есөн сая долоон зуун наян гурван мянга гурван зуун тавин зургаа/ төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2-т "Худалдан авах гэрээнд дараахь өөрчлөлт хийхийг хориглоно: энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үнэ нэмэгдүүлэн олгосон 9,783,356.0 /есөн сая долоон зуун наян гурван мянга гурван зуун тавин зургаа/ төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Тосон Илч ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бямбацогт, нягтлан бодогч П.Мөнхбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР
Ч.ЭНХЧИМЭГ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот